

ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ (2025 оны I улирлын түүвэр судалгааны тайлан)

Судалгааны товч үр дүн

Шинжээчдийн макро эдийн засгийн төсөөллийн судалгааг 2025 оны 2-р сарын 17-27-ний өдрүүдийн хооронд банкуудын эдийн засагчид, их дээд сургуулиудын багш нар, судалгааны болон үнэт цаасны компаниудын нийт 25 шинжээчийн дунд явуулж, судалгааны үр дүнг дараах байдлаар нэгтгэн танилцуулж байна.

Шинжээчид:

2025 оны I улиралд

- Инфляц бага зэрэг нэмэгдэж 10.1%,
- Эдийн засгийн өсөлт өнөөгийн түвшинд 4.9%,
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 10.1%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 16.9% байна гэж таамагласан байна.

2025 оны IV улиралд

- Инфляц өнөөгийн түвшинд 9.7%,
- Эдийн засгийн өсөлт хурдасч 5.4%,
- Бодлогын хүү бага зэрэг нэмэгдэж 10.7%,
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.0% байна гэж таамагласан байна.

Судалгааны нэгдсэн үр дүн

Огноо	2025 он 1 сар	2025 он I улирал	2025 оны IV улирал
Инфляц /ХҮИ-ийн жилийн өсөлт, УБ хот, %/	9.7%	10.1%	9.7%
Эдийн засгийн өсөлт /Бодит ДНБ-ий жилийн өсөлт, %/	4.9%*	4.9%	5.4%
Төв банкны бодлогын хүү /%/	10.0%	10.1%	10.7%
Олгосон зээлийн дундаж хүү /₮, %/	16.9%	16.9%	17.0%

* 2024 оны 4-р улирал


Энэхүү улирал тутмын түүвэр судалгааны тайлангийн агуулга нь зөвхөн банкууд, хувь шинжээч, судлаачдын таамаглалыг нэгтгэсэн үр дүнг илэрхийлэх бөгөөд Монголбанкны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© МОНГОЛБАНК, 2025

I. Инфляц


2024 оны IV улиралд Улаанбаатар хотын жилийн инфляц 9.7% болж нэмэгдсэн бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 2.2 нэгж хувиар дээгүүр гарсан байна. Шинжээчид 2025 оны I улиралд инфляц 10.1%, оны эцэст 9.7% болно гэж таамаглаж байна (Зураг 1).

Зураг 1. Инфляцын таамаглал




Шинжээчдийн инфляцын таамаглалын тархалтыг авч үзвэл 2025 оны I улиралд инфляц 9.0-9.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.1%, 10.0-10.9 хувийн хооронд байх магадлал 29.7%-тай байна. Өмнөх улирлын судалгаагаар 2025 оны I улиралд инфляц 7.0-7.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 32.9% гэж таамаглаж байжээ (Зураг 2).

Зураг 2. Инфляцын таамаглалын тархалт /2025 оны I улирал/




Энэ удаагийн инфляцын таамаглалын үр дүнг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад өссөн хэдий ч цаашид энэ түвшинд тогтворжих хандлагатай байна. Шинжээчид 2025 оны I улирлын инфляцыг өмнөх улирлын судалгаагаар 7.8% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 10.1% гэж таамаглажээ (Зураг 3).

Зураг 3. Инфляцын өмнөх таамаглалуудын харьцуулалт



Инфляцын таамаглалыг тоон хариултын дунджаас гадна тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 9.9-10.0% байна (Зураг 4).


Зураг 4. Ирэх улирлын инфляцын таамаглал /2025 оны I улирал/



II. Эдийн засгийн өсөлт


2024 оны IV улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 4.9% гарсан бөгөөд энэ нь өмнөх улирлын шинжээчдийн таамаглалын дунджаас 0.6 нэгж хувиар бага гаржээ. Шинжээчид бодит ДНБ-ий жилийн өсөлт 2025 оны I улиралд 4.9%, 2025 оны эцэст 5.4% гэж таамаглаж байна (Зураг 5).

Зураг 5. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалтыг авч үзвэл 2025 оны I улиралд 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.6% байна. Өмнөх улирлын судалгаагаар 2025 оны I улиралд өсөлт 5.0-5.9 хувийн хооронд байх магадлал хамгийн өндөр буюу 30.1% гэж таамаглаж байжээ (Зураг 6).

Зураг 6. Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалын тархалт /2025 оны I улирал/




Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг өмнөх түүвэр судалгаануудын таамаглалуудтай харьцуулахад буурсан бөгөөд цаашид бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Шинжээчид 2025 оны I улирлын бодит ДНБ-ий жилийн өсөлтийг өмнөх улирлын судалгаагаар 6.0%-д хүрнэ гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар 4.9% байна гэж таамаглажээ (Зураг 7).

Зураг 7. Бодит ДНБ-ий өсөлтийн өмнөх таамаглалуудын харьцуулалт



Бодит ДНБ-ий өсөлтийн таамаглалыг тоон хариултын медиан болон таамаглалын тархалтын дундаж утгаар тооцон үзэхэд дундажтай ойролцоо түвшинд буюу 5.0-5.1% орчимд байна (Зураг 8).


Зураг 8. Ирэх улирлын бодит ДНБ-ий өсөлтийн таамаглал /2025 оны I улирал/



Ш. Бодлогын хүү


Шинжээчид төв банкны бодлогын хүүг 2025 оны I улиралд дунджаар 10.1%, хамгийн ихдээ 11.0%, хамгийн багадаа 10.0% гэсэн хүлээлттэй байна. Цаашид бодлогын хүү өнөөгийн түвшнээс бага зэрэг өсөж 2025 оны эцэст 10.7% байна гэж таамаглажээ (Зураг 9).

Зураг 9. Бодлогын хүүний таамаглал



Бодлогын хүүний таамаглалыг тархалтаар нь авч үзвэл шинжээчдийн дийлэнх нь 2025 оны I улиралд бодлогын хүү 10.0% байна гэсэн таамаглалтай байна (Зураг 10).


Зураг 10. Бодлогын хүүний таамаглалын тархалт /2025 оны I улирал, хариултын тоогоор/



2022 оны эхэн үеэс үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор бодлогын хүүг аажмаар нэмэгдүүлсээр мөн оны эцэст 13% хүргэсэн бол 2024 оны I улирлаас бодлогын хүүг бууруулж, өнөөгийн байдлаар 10%-д хүргээд байна. Үүнтэй холбоотойгоор сүүлийн улирлуудад шинжээчдийн таамаглал буурах хандлага ажиглагдаж байсан бол оны эцэст бага зэрэг

нэмэгдэх төлөвтэй байна. Өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2025 оны I улирлын бодлогын хүүг 10.3% байна гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар өнөөгийн түвшинд 10.1% байна гэж таамаглажээ (Зураг 11).


Зураг 11. Бодлогын хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт



IV. Зээлийн хүү


Шинжээчид төгрөгийн шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүүг 2025 оны I улиралд дунджаар 16.9%, хамгийн ихдээ 17.2%, хамгийн багадаа 16.3%-тай байна гэж таамаглажээ. Цаашид зээлийн хүү өнөөгийн түвшинд хэвээр 17.0% орчим байхаар таамагласан байна (Зураг 12).

Зураг 12. Зээлийн хүүний таамаглал



Зээлийн хүүний таамаглалын тархалтаас харвал 2025 оны I улиралд зээлийн жигнэсэн дундаж хүүг 16.8-17.1% байна гэсэн таамаглал давамгайлж байна (Зураг 13).

Зураг 13. Зээлийн хүүний таамаглалын тархалт /2025 оны I улирал, хариултын тоогоор/



Энэ удаагийн зээлийн хүүний таамаглал нь өмнөх улирлын түүвэр судалгааны үр дүнтэй ойролцоо түвшинд байна. Сүүлийн улирлуудад шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү

харьцангуй тогтвортой байгаатай холбоотойгоор шинжээчдийн таамаглал мөн тогтворжиж байна. Тухайлбал, өмнөх улирлын судалгаагаар шинжээчид 2025 оны I улиралд зээлийн хүүг 16.9% гэж таамаглаж байсан бол энэ удаагийн судалгаагаар мөн адил 16.9% гарна гэж үзсэн байна (Зураг 14).

Зураг 14. Зээлийн хүүний өмнөх таамаглалуудын харьцуулалт

